



**ЗАВХАН АЙМГИЙН
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБА
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАНИЛЦУУЛГА**

2023 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 07

Улиастай

Шалгалт хийсэн дүнгийн тухай

Албаны 2023 оны дотоод аудитын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу даргын баталсан 38 дугаар удирдамжаар Завхан аймгийн Улиастай сумын ЕБ-ын 3-р сургуулийн 2021, 2022 оны санхүү аж ахуйн үйл ажиллагаанд 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс Дотоод аудитор-санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч Б.Батхүү ахлан, Дотоод аудитор-санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч Ц.Мядагмаа нар дотоод аудит хийж гүйцэтгэсэн ажлын тайланг танилцуулж байна

Шалгалтын зорилго

Тус байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл явцуудын үр нөлөөтэй байдлыг үнэлж дүгнэх, тус байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн зөвлөгөө өгөх замаар байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэхэд оршино.

Хамрах хүрээ

Хуулийн этгээдийн бүртгэл, харилцах дансны мэдээлэл:

Тус байгууллага нь 2021, 2022 онд улсын бүртгэлийн 9039791 дугаартай үндсэн үйл ажиллагааны Төрийн сан дахь 100091715103, 100091715162 нэмэлт санхүүжилтын 100091715403 дансуудаар үйл ажиллагаагаа явуулж ирсэн байна.

Төсвийн хөрөнгө зарцуулах эрхийн талаар:

2021, 2022 онд хөрөнгө зарцуулах эрхийн 1-р гарын үсгийг дарга Д.Одончимэг, Б.Буяннэмэх 2-р гарын үсгийг нягтлан бодогчоор ажиллаж байсан агсан Г.Алтанцэцэг, бичиг хэрэг О.Буянхишиг, нягтлан бологч М.Алтанцэцэг нар зурж хөрөнгийг зарцуулан иржээ.

Үйл ажиллагааны орлого, зарцуулалт:

2021 оны төсвийн гүйцэтгэлээр улсын төсвөөс 1342784.8 мянган төгрөгийн санхүүжилт авч цалин НДШ-д 71%, байр ашиглалтай холбоотой тогтмол зардалд 10,1%, бусад зардалд 18,9%, тус онд орон нутгийн төсвөөс нэмэлт санхүүжилтээр 82197,7 мянган төгрөгийг бараа үйлчилгээ болон хангамж материалын зардалд 26,5%, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийн зардалд 67,8%, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжид 5,7%-ийн зардлыг тус тус зарцуулжээ

2022 оны төсвийн гүйцэтгэлээр 1702781.2 мянган төгрөгийн санхүүжилт авч цалин, НДШ-д 68,6%, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 19,9%, бусад зардалд 11,5%-ийг тус тус зарцуулжээ

Илэрсэн зөрчил:

2021 оны 03 сарын 01-ний Б/01 тушаалд Хөдөлмөрийн тухай хуулийн 7.103.1 гэх буруу заалт үндэслэсэн

2021 оны 08 дугаар сарын 23-ны Б/06 тушаал хөдөлмөрийн тухай хуулийн 7.104 дахь буруу заалт үндэслэсэн

2021 оны 09 дүгээр сарын 01-ний Б/13 дугаар тушаалд хөдөлмөрийн тухай хуулийн 5.80.1 гэх буруу заалт үндэслэсэн

2021 оны 01 сараас 10 хүртэл хугацаанд ажилчдын хоолны мөнгийг 7500-50000 хооронд тэгш бус байдлаар олгосон

2022 оны 06 сарын 20-ны А/33 тушаалаар багш ажилчдын аялалд явсан тээврийн хөлсний зардлыг төсвөөс санхүүжүүлсэн 1000000 төгрөг энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12.1.2 ээлжийн амралтаараа дотоодын амралт, сувиллын газарт, эсхүл өөрийн болон эхнэр /нөхөр/-ийн төрсөн нутагт амрах тохиолдолд түүний очих, ирэх замын зардал гэснийг зөрчсөн /аудитаас төлбөр тогтоогдсон/

2022 оны 10 сарын 20-нд хүүхдийн хоолны зардлаас вакус, 700гр-тай чихэр авч төсвийн зориулалт бус зардал гаргасан 312200 төгрөг

2022 оны 12 сарын 23-нд Миний тулга ХХК-д өмнөх оны өр төлбөрийг тайланд тусгалгүй төлсөн 2400000 /2021 онд миний тулга ххк-аас сүү, мах бэлтгэн нийлүүлээгүй байна/

2021 онд Х.Ууганбаярын дансаар дамжуулан багш нарын туршлага судлах зардалд бараа үйлчилгээний бусад зардлаас захирлын 2022/12/21-ний А/63 тушаалаар зарцуулалтын тайлагналтгүй хөрөнгө зарцуулсан 3636037 төгрөг

2022 оны 12 сарын 23-нд Д.Оюунжаргалаас 449*11000/4939000 төгрөгийн үхрийн мах нөөцлөх зориулалтаар авсан, алтан үзэг ххк-аас 2822620 төгрөгийн бичиг хэргийг тухайн жилийн хэмнэгдэх зардлаас авсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.6 нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөхийг хориглоно гэснийг зөрчсөн

2021 оны 06 сарын 29-нд актын төлбөр 3150000 төгрөгийг төсвөөс төлсөн

Төлбөр

Хичээл үйлдвэрлэлийн зардлаас чипс, хиам зэрэг материал авч төсвийн зориулалт бус зардал гаргасан /Элтизэ ХХК шийдвэргүй/ 175340 төгрөг

Хичээл үйлдвэрлэлийн зардлаас хавсай авч төсвийн зориулалт бус зардал гаргасан /Завхан хүнс Атар ХХК шийдвэргүй/ 81000 төгрөг

Т.Мөнхсайханаас хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас хонины мах авч төсвийн зориулалт бус зардал гаргасан 170000 төгрөг

Отгонтөгс-д хүүхдийн хоолны зардлаас баримтгүй хөрөнгө зарсан /материалын тайланд тусгаагүй/ 2002000 төгрөг

ГДЖЭ ХХК-аас кола, гоё, цэвэр ус авч зориулалт бус зардал гаргасан /хүүхдийн хоолны зардлаас шийдвэргүй/ 440000 төгрөг

2021/12/21-ний А/55 тушаалаар Н.Лхагвасүрэнд төгсөгчдийн тэмцээнд зориулж 746800 төгрөгийг тушаалд тусгасан дүнгээс илүү олгосон, зарцуулалтын тайлагналтгүй

Дээрх зөрчилтэй холбоотой нийт **3 615 140** төгрөгийн нөхөн төлбөрийн акт тогтоон ажиллав.

Дүгнэлт

Багш нарт үр дүнгийн урамшуулал, ур чадварын нэмэгдэл олгохдоо хийсэн ажлын үзүүлэлт гаргасан амжилт, ажлын үр дүнг харгалзан үзэж урамшуулдаг байх

Байгууллагын дотоод журмыг хууль эрх зүйн хүрээнд боловсруулах

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт хүргүүлж ажиллах

Сангийн сайдын 2000 оны 04 дүгээр сарын 28-ны 69-р тушаалын дагуу эд хариуцагчийн тайлан хөтлөлтөө бүртгэх

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14-р зүйлд нягтлан бодох бүртгэл хөтлөх 14.3-д нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ, 14.4.3 бүх өр төлбөр гэж заасан тул өглөг авлагаа хууль эрх зүйн хүрээнд жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгаж барагдуулдаг байх

Иргэний хуулийн 343 дугаар зүйлийн 343.1 "ажил гүйцэтгэх гэрээгээр ажил гүйцэтгэгч нь захиалагчийн буюу өөрийн материалаар гэрээнд заасан ажил гүйцэтгэх, захиалагч нь уг ажлын үр дүнг хүлээн авч, хэлэлцэн гэрээнд тусгасны дагуу ажлын хөлс олгодог байх

"Төсвийн тухай хууль"-ийн 6-р зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах" мөн хуулийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" 41-р зүйлийн 41.2.2-д батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах

Санхүүгийн үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээ хийгдээгүй, эрсдэлийн удирдлага хангалтгүй байгаа тул эрсдэлийн үнэлгээ хийж урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ авах.

Дотоод хяналтын нэгжийг хараат бус байлгах зарчмаар байгуулан, төсөв санхүүтэй холбоотой өдөр тутмын үйл ажиллагаандаа хандуулах.

Танилцуулга бэлтгэсэн:

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны
ДА-СХШУБ

Ц. Мятагмаа

